



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 4/67

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны “Угийн бичгийн хөтлөлтийг эрчимжүүлэх тухай” А/01 дүгээр албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголчуудын оршихуйн соёлын нэн үнэт өв “Угийн бичиг”-ээ үеэс үе дамжуулан үр хүүхэд, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сумын нийт ард, иргэдэд сурталчилах, өрх бүрээр хөтлүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: 3. Цэцэгмаа - Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Г. Ууганбаяр - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Б. Лхагвадулам - Сумын Номын сангийн эрхлэгч

Ш. Баярмаа - Ерөнхий боловсролын сургуулийн

Монгол хэл бичгийн багш

Б. Цэрэнноров - Насан туршийн боловсролын багш

Б. Пагамдулам - 1 дүгээр багийн Засаг дарга

Д. Батбаяр - 2 дугаар багийн Засаг дарга

Д. Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга

Д. Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга

Ц. Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга

Ц. Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

2. Сум, багийн түвшинд “Угийн бичиг хөтлөх” ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэгт, төрийн албан хаагч бүр өөрийн удмын “Угийн бичгийг хөтөлж”, ойр дотно найз нөхдийн хүрээнд 5 өрхийг сонгон “Угийн бичиг”-ээ хөтөлж хэвшүүлэхэд дэмжин ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийн явцыг жилд 2 удаа Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (3. Цэцэгмаа), Соёлын төвийн эрхлэгч (О. Долгормаа) нарт даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Т. БАЯРМОНХ